

БАТЛАВ  
 БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
 ДАРГА Д. ДЭЛГЭРМАА

2020 оны 05 сарын 12 өдөр

2020 ОНД БАЯНГОЛ ДҮҮРЭГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ДЭЭВРИЙН ЗАСВАРЫН АЖИЛ  
 ГҮЙЦЭТГЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2020 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 05/10

Улаанбаатар хот

1	Ажил гүйцэтгэх үндэслэл	Нийслэлийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/309 дүгээр захирамж
2	Барилга байгууламжийн байршил	<ol style="list-style-type: none"> <li>1. Баянгол дүүргийн 8 хороо 25/1 дүгээр байр</li> <li>2. Баянгол дүүргийн 8 хороо 25/2 дугаар байр</li> <li>3. Баянгол дүүргийн 8 хороо 39 дүгээр байр</li> <li>4. Баянгол дүүргийн 12 хороо 12 дугаар байр 3, 4-р орц</li> <li>5. Баянгол дүүргийн 12 хороо 276 дүгээр байр</li> <li>6. Баянгол дүүргийн 12 хороо 18а дүгээр байр</li> <li>7. Баянгол дүүргийн 13 хороо 2д байр</li> </ol>
3	Зориулалт, хүчин чадал	- Дээврийн засвар 4861м2 /тоо хэмжээний дэлгэрэнгүйг хавсралт-1-ээс харах/
4	Зураг төсөл, бүрдэл	<u>Баримт бичгийн иж бүрдэл:</u> - Магадлалын дүгнэлт <u>Зураг төслийн иж бүрдэл:</u> - Хэмжилтийн ажлын зураг - Барилгын төсөв /магадлалаар баталгаажсан/
5	Ажил гүйцэтгэх үе шат, хугацаа	<u>2 үе шаттай.</u> <ol style="list-style-type: none"> <li>1. Дээврийн засварын хэмжилтийн ажлын зураг боловсруулж, төсөвт магадлал хийлгэх.</li> <li>2. Барилга угсралтын ажил гүйцэтгэж, хүлээлгэж өгөх.</li> </ol> Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
6	Ажил гүйцэтгэх байгууллага	- Холбогдох тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий байгууллага.
7	Хөрөнгө оруулагч (захиалагч) байгууллага	- Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар
8	Онцгой нөхцөл	<u>Аюулгүй байдал хангах ажил:</u> - Ажил эхлэхээс өмнө Сууц өмчлөгчдийн холбоо, иргэд, оршин суугчдад мэдэгдэл өгөх, ажлын дараалал, гүйцэтгэх хугацааг тодорхой болгож мэдээллийн самбар байршуулна. - Иргэд, оршин суугчдын явган болон авто машин зорчих хэсгийн аюулгүй байдлыг хангах, таних тэмдэг байршуулна. <u>Дээвэр хуулж, буулгаж тээвэрлэх ажил:</u> - Дээвэр дээрх холбооны болон цахилгааны утас цэгцэлж ажил хийхэд саадгүй болгоно. - Дээврийн хар цаасыг бүрэн хуулж гарсан хог, хаягдлыг цэвэрлэж ажил эхлүүлэх бэлтгэл хангана. - Ажил гүйцэтгэхээс өмнө дээврийн хог, хаягдлыг зориулалтын шат ашиглан буулгаж дор бүр нь тээвэрлэнэ.

Бохирын болон агааржуулах хоолойн засварын ажил:

- Агааржуулалтын хоолой тоосгон өрлөг хийцтэй бол нурсан хэсгийг буулгаж нөхөн сэргээлт хийж, зориулалтын бетон тавцанг шинээр солино.
- Эвдэрч гэмтсэн, шаардлага хангахгүй байгаа бохирын яндан хоолойг шинээр солих, зориулалтын агааржуулалтын малгайвч хийнэ.
- Үерийн ус зайлуулах хоолойн хог, лаг, шавар цэвэрлэж хамгаалалтын төмөр тор хийх, шаардлагатай бол ус зайлуулах хоолойг шинээр солих буюу засварлана.

Бетон зуурмагийн ажил:

- Хар цаасан дээвэр хуулсаны дараа борооны усны налууг нарийн тооцоолж 50-150 мм зузаантайгаар бетон зуурмагаар зутгаж өнгөлгөө, тэгжилгээ хийнэ.
- Бетон зуурмагийг зориулалтын помп машинаар цутгана.
- Цутгалт хийхдээ парапетны ханаруу хар цаасыг нугалаа үүсгэхгүй байхаар тооцоолж уналтын налуу гаргана.
- Бетоны марк М150-аас багагүй байна.

Дээврийн хуйлмал материалын ажил:

- Праймер буюу суурь түрхлэгийн ажлыг технологийн дагуу хөрсжүүлэлт хийнэ.
- Хар цаасыг чулуугүй нэг үе, чулуутай нэг үе нийт хоёр үе байх ба хамгийн сайн чанартай хуйлмал материал байна.
- Хуйлмал материалыг парапед ханаруу цоройтгон стандартын дагуу нааж өгнө.
- Дээврийн жижиг хийцүүд болох агааржуулалтын яндан, хоолойруу заавал хөрсжүүлэлт түрхэж цоройтгон наах ба бөгж төмөрөөр бэхэлгээ хадаж, силикон буюу мастекаар хуйлмал материалын ам дарж бэхжүүлэлт шаваас хийж өгнө.
- Хуйлмал материал наах үед жижиг цоорхой урагдалт гарвал тэр хэсгээр нь тайрч зөрүүлэн нааж өгнө.
- Хуйлмал материалыг 100мм-ээс багагүй зөрүүлэг хийж нааж өгнө.

Парапедны засвар, шинэчлэлийн ажил:

- Парапедны төмөр сэргээн засварлах, шаардлагатай бол шинээр солино.
- Парапед хана нурсан, эвдэрсэн бол шаардлагатай нөхөн сэргээх өрлөг, шавар хийж засварлана.
- Байгалийн давагдашгүй хүчин зүйл болох /хуй салхи, аадар бороо/ хийсэхгүй, ус орохгүй байхаар тооцоолж парапед төмөрийг хоёр талаас нь хадаж бэхэлгээ хийж өгнө.

Өөрчлөлт оруулсан байрны дээврийн засварын ажил:

- 13 хороо 2д байранд мембран хуйлмал материалыг ашиглана.
- Мембран хуйлмал материалыг хийхээс өмнө ажлын талбайг цэвэрлэж хөндийрсөн, овойсон хэсгийг авч шавран тэгшилгээ хийнэ.
- Ажлын талбайг цэвэрлэж барилгын хогоо буулгах бөгөөд хөрсжүүлэлт /праймер/-ийг 2 үе түрхэнэ.
- Мембран хуйлмал материалыг парапед ханаруу наасан хэсгийг зориулалтын ам дарагч төмөрөөр хадаж бэхжүүлж өгнө.
- Мембран хуйлмал материалыг наандаа зориулалтын

		<p>цавуугаар наах бөгөөд стандартын дагуу амьсгалуулагч хийж өгнө.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Парapedны төмөр шинээр солино.</li> </ul> <p>Цаг агаарын нөхцөл байдалтай уялдуулан ажлын төлөвлөгөө, график гарган иргэд, оршин суугчдад хохирол учруулалгүй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахиун шаардлага ханган ажиллана.</p>
9	Галын аюулгүй байдлын нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм /БНБД 21.02.02/, /БНБД 21.01.02/</li> </ul>
10	Ажил гүйцэтгэхэд ашиглах материал	<p><u>Хууль тогтоомжууд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Барилгын тухай Монгол улсын хууль</li> </ul> <p><u>Норм, стандартууд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Дээврийн ажил БНБД 31-07-05</li> <li>- Барилга угсралтын ажилд хэрэглэгдэх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД 12-101-05</li> <li>- Дээвэр болон ус тусгаарлалтын хуйлмал материал. Техникийн ерөнхий шаардлага MNS 6303-2011</li> <li>- Ус үл нэвтрүүлэх хуйлмал материал ТУ 5774-002-13157915-98</li> <li>- Гөлмөн төмөр MNS 3154-1984</li> </ul>
11	Эдийн засгийн тооцоо, төсөв	<ul style="list-style-type: none"> <li>- Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох.</li> </ul>


ХЯНАСАН

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Т.МӨНГӨНТУЛГА

БОЛОВСРУУЛСАН

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ОРОН СУУЦ,  
НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИДГЭЭ, СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБОО  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

 Ч.ГАНХУЯГ

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ  
2020 ОНД БАЯНГОЛ ДҮҮРЭГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ДЭЭВРИЙН ЗАСВАРЫН АЖИЛ  
ГҮЙЦЭТГЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

2020 оны 05 дугаар сарын 12

Улаанбаатар хот

№	Орон сууцны байруудын байршил	Ажлын тоо хэмжээ /м2/	Тайлбар
1	Баянгол дүүргийн 8 хороо 25/1 дүгээр байр	1100	Хавтгайлжин
2	Баянгол дүүргийн 8 хороо 25/2 дугаар байр	1100	Хавтгайлжин
3	Баянгол дүүргийн 8 хороо 39 дүгээр байр	512	Хавтгайлжин
4	Баянгол дүүргийн 12 хороо 12 дугаар байр 3, 4-р орц	700	Хавтгайлжин
5	Баянгол дүүргийн 12 хороо 27б дүгээр байр	250	Хавтгайлжин
6	Баянгол дүүргийн 12 хороо 18а дүгээр байр	300	Хавтгайлжин
7	Баянгол дүүргийн 13 хороо 2д байр	899	Хавтгайлжин
<b>Нийт 4 байр</b>		<b>4861</b>	